



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/25

Хэрлэнбаян-Улаан тосгон

Мал тэжээвэр амьтан, хашаа,
худгийн тооллого явуулах тухай

Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.в, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтууд, аймгийн Засаг даргын 2024 оны А/622 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тосгоны нутаг дэвсгэрт 2024 оны жилийн эцсийн Мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн тооллогыг 2024 оны 12 дугаар сарын 07-оос 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрүүдэд явуулсугай.

2. Мал тэжээвэр амьтан, хашаа, худгийн 2024 оны жилийн эцсийн тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	А.Нарантуяа	Санхүү албаны дарга
	Д.Болормаа	МААҮТММҮБАХМ Мэргэжилтэн
	Ю.Батбаяр	Нягтлан бодогч
	Н.Ганцэцэг	Нярав
	О.Эрдэнэбат	Жолооч

3. Жилийн эцсийн мал тооллогын ажлыг хуулийн хүрээнд хугацаанд нь чанартай зохион байгуулж дүн мэдээг нэгтгэн хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Ж.МАРТ